

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2019 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Агуулга

1. Аудитын гэрчилгээ	2
2. Аудитын тайлан	4
2.1. Оршил	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	7
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	7
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	7
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	8
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	9
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	9
2.12. Шилэн дансны мэдээлэл.....	10
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	10
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	10
3. Менежментийн захидал.....	11
4. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	13
4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	13
4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	14
4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	15
4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	17
4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	18
5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	19

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
АХБ	Азийн Хөгжлийн Банк
МУЗГ	Монгол Улсын Засгийн Газар
ТУХ	Төслийн Удирдах Хороо
ТХН	Төслийн Хэрэгжүүлэх Нэгж



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

УРГАМАЛ, МАЛЫН ЭРҮҮЛ АХУЙ,
ХҮНСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ
ХАНГАХ АРГА ХЭРЭГСЛИЙГ
САЙЖРУУЛАХ ТӨСЛИЙН
ЗОХИЦУУЛАГЧ Э. ЦОГОО ТАНАА

2020.05.04 № 06/1481
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу “Ургамал, малын эрүүл ахуй, хүнсний аюулгүй байдлыг хангах арга хэрэгслийг сайжруулах төсөл”-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

“Ургамал, малын эрүүл ахуй, хүнсний аюулгүй байдлыг хангах арга хэрэгслийг сайжруулах төсөл”-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдлын тайлан, санхүүгийн үр дүнгийн тайлан, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар “Ургамал, малын эрүүл ахуй, хүнсний аюулгүй байдлыг хангах арга хэрэгслийг сайжруулах төсөл”-ийн 2019 оны санхүүгийн тайлан, тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагын мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. Аудитын тайлан

2.1. Оршил

“Ургамал, малын эрүүл ахуй, хүнсний аюулгүй байдлыг хангах арга хэрэгслийг сайжруулах төсөл”-ийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төслийн зохицуулагч Э.Цогоо Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчид Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн заавар, аргачлалд нийцсэн санхүүгийн програм хангамж ашиглах, Шилэн дансны тухай хуулийг дагаж мөрдөх зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу “Ургамал, малын эрүүл ахуй, хүнсний аюулгүй байдлыг хангах арга хэрэгслийг сайжруулах төсөл”-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

“Ургамал, малын эрүүл ахуй, хүнсний аюулгүй байдлыг хангах арга хэрэгслийг сайжруулах төсөл”-ийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 03 дугаар сарын 25-наас 2020 оны 04 дугаар сарын 20-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 04 дүгээр сарын 14-ний өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Далайван Аудит ХХК-ийн захирал Ц.Жигдэн хянан удирдаж, чанарын хяналтын менежер М.Болормаа, аудитор Ж.Жаргалсүрэн нар хэрэгжүүлэв.

“Ургамал, малын эрүүл ахуй, хүнсний аюулгүй байдлыг хангах арга хэрэгслийг сайжруулах төсөл”-ийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 03 дугаар бүхий албан бичгээр хуулийн хугацаанд хүргүүлсэн байна. Далайван Аудит ХХК нь 2020 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн 19 тоот албан бичгээр төслийн нэгжийн санхүүгийн тайланг хүлээн авч аудитын ажлыг эхлүүлсэн.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБООУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

МУЗГ, АХБ-ны хооронд 2016 оны 01 дугаар сарын 08-ны өдөр байгуулсан зээлийн хэлэлцээрээр нийт 16.2 сая ам.долларын өртөгтэй “Ургамал, малын эрүүл ахуй, хүнсний аюулгүй байдлыг хангах арга хэрэгслийг сайжруулах төсөл”-ийг хэрэгжүүлэхэд АХБ-ны ердийн хөрөнгийн эх үүсвэрээс 15.0 сая ам.долларын зээл олгохоор болсон. Зээлийн хэлэлцээр нь 2016 оны 03 дугаар сарын 28-ны өдрөөс хүчин төгөлдөр болсон. Төсөл хаах хугацаа 2021 оны 06 дугаар сарын 30-ны өдөр байсныг 2022 оны 06 дугаар сарын 30-ны өдөр болгож сунгасан. МУЗГ-аас 1.2 сая ам.долларыг мөнгөн бус хэлбэрээр буюу татварын чөлөөлөлт үзүүлэх замаар санхүүжүүлнэ.

Төсөл нь Төв Азийн бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааны коридорын дагуу хүн, ургамал, малын эрүүл ахуйн шаардлагад нийцүүлэхүйц ургамал, малын гаралтай бүтээгдэхүүний худалдааг өргөжүүлэх, Монгол Улсын эдийн засгийг төрөлжүүлэн, дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээг өсгөх ерөнхий зорилготой. Энэ хүрээнд хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний экспорт, импортын процессийн хяналт, шинжилгээний тогтолцоо, түүний стандарт, барилга байгууламж, тоног төхөөрөмжийг шинэчлэн сайруулах зорилготой.

Үйл ажиллагааны чиглэл: Төслийн үр дүнг дараах хүрээг хамаарна.

- Үр дүн 1. Лаборатори, хилийн боомтын хяналт шалгалт болон хорио цээрийн байгууламжийг шинэчлэх
- Үр дүн 2. Хяналт, шалгалтын удирдлагын тогтолцоог бүрдүүлэх
- Үр дүн 3. Хяналт, шалгалтын үйл ажиллагаа
- Үр дүн 4. Төслийн удирдлага

Тайлант оны эцсийн байдлаар өссөн дүнгээр нийт 1.6 сая долларын гэрээ байгуулж, 1.7 сая ам.долларын зарцуулалт хийсэн байна. 2019 онд 0.7 сая долларын гэрээ байгуулж, 0.9 сая ам.долларын зарцуулалт хийсэн байна.

“Ургамал, малын эрүүл ахуй, хүнсний аюулгүй байдлыг хангах арга хэрэгслийг сайжруулах төсөл” нь 2018 оны санхүүгийн тайлангаа Шадар сайдын нэгтгэсэн санхүүгийн тайланд өгч нэгтгүүлсэн.

Улсын Их Хурлаас Монгол Улсын 2019 оны жилийн төсвийг батлахдаа Засгийн газрын шугамаар хэрэгжиж байгаа зээл, тусламжийн бүх төсөл хөтөлбөрүүд Сангийн сайдын багцад шилжүүлэн баталсан. Үүнтэй холбоотойгоор төсөл нь 2018 оны 12 сарын 31-нээр тасалбар болгосон хаалтын тайлангаа Шадар сайдын нэгтгэсэн санхүүгийн тайланд өгч, Сангийн яаманд балансын тэг үлдэгдэлтэй шилжсэн.

“Ургамал, малын эрүүл ахуй, хүнсний аюулгүй байдлыг хангах арга хэрэгслийг сайжруулах төсөл”-ийн удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНБООУС, түүнд нийцүүлэн баталсан төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэлийн журам, зааврын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль

- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Татварын багц хуулиуд
- Нийгмийн даатгалын тухай хууль
- Сангийн сайдын 2015 оны 196 дугаар тушаалаар батлагдсан “Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журам”
- Сангийн сайдын 2007 оны 326 дугаар тушаалаар батлагдсан “Засгийн газрын санхүүгийн нэгдсэн тайлангийн бүрэлдэхүүн болох Засгийн газрын шугамаар авч, ашиглаж буй хөнгөлөлттэй зээл болон буцалтгүй тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөр, засгийн газрын тусгай санд мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”
- Сангийн сайдын 2006 оны 388 тоот тушаалаар батлагдсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар, санхүүгийн тайлан бэлтгэж гаргах аргачлал”.

Тайлант хугацаанд төслийн нэгжийн санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хууль, тогтоомж, түүнд нийцүүлэн гаргасан заавар, аргачлалд томоохон шинэчлэлт, өөрчлөлт ороогүй байна.

Харин татвар, нийгмийн даатгалын холбогдох хуульд орсон дараах өөрчлөлтүүд нөлөөлсөн. Үүнд:

- Нийгмийн даатгалын тухай хуулиар ажил олгогч болон даатгуулагчаас төлөх шимтгэлийн хувийг 0.5 хувиар нэмэгдүүлсэн;
- Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд заасан хөнгөлөгдөх татварын хэмжээг татвар ногдуулах орлогын хувь хэмжээнээс хамаарч өөрчлөлт орсон;

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус төсөл нь өөрийн үйл ажиллагаанд тохирсон нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулаагүй.

“Ургамал, малын эрүүл ахуй, хүнсний аюулгүй байдлыг хангах арга хэрэгслийг сайжруулах төсөл” нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд “Инфосистемс” ХХК-ийн “Пакс” программ хангамж ашигладаг байна.

“Ургамал, малын эрүүл ахуй, хүнсний аюулгүй байдлыг хангах арга хэрэгслийг сайжруулах төсөл”-ийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

Төсөл нь төлөвлөсөн үйл ажиллагааг тогтоосон хугацаанд, үр дүнтэй хэрэгжүүлэх, зээлийн хөрөнгийг зорилгын хүрээнд үр ашигтай зарцуулах, хэрэгжилтэд хяналт шинжилгээ хийх, үр дүнг тайлагнах, ил тод байдлыг хангахын тулд төслийн гүйцэтгэлийн хяналт, санхүүгийн хяналт, худалдан авах үйл ажиллагааны хяналтыг хэрэгжүүлдэг. АХБ болон төслийн гүйцэтгэгч байгууллагаас төслийн үйл ажиллагааны үе шат бүрт хяналт тавьж ажилладаг.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар “Ургамал, малын эрүүл ахуй, хүнсний аюулгүй байдлыг хангах арга хэрэгслийг сайжруулах төсөл”-ийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын гүйцэтгэлийн үе шатанд 3 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүнг сонгож, эрсдэлийн түвшинг “бага” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төслийн зардлын гүйцэтгэлд үндэслэн гадаад зээлийн эх үүсвэрээс санхүүжилт хүлээн авдаг. Иймээс нийт зардлын дүнг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 906,512.9 мянган төгрөгөөс 18,130.3 мянган төгрөгөөр тооцон материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа. Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг өөрчлөөгүй болно.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

“Ургамал, малын эрүүл ахуй, хүнсний аюулгүй байдлыг хангах арга хэрэгслийг сайжруулах төсөл”-ийн 2019 оны санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,518,878.8 мянган төгрөгөөр өссөн байна. Өмнөх оны үзүүлэлттэй харьцуулахад дуусаагүй барилга, урт хугацаат өр төлбөр, хуримтлагдсан үр дүн дансдад материаллаг өөрчлөлт гарсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	636,289.7	1,035,655.0	399,365.3
Урьдчилж гарсан зардал	-	717.9	717.9
Үндсэн хөрөнгө	172,959.5	175,643.7	2,684.2
Хуримтлагдсан элэгдэл	(29,764.7)	(52,890.4)	(23,125.7)
Биет бус хөрөнгө	4,600.0	4,600.0	-
Хуримтлагдсан элэгдэл	(690.0)	(1,150.0)	(460.0)
Дуусаагүй барилга	-	1,139,697.1	1,139,697.1
Нийт хөрөнгө	783,394.5	2,302,273.3	1,518,878.8
Урт хугацаат өр төлбөр	2,190,097.9	-	(2,190,097.9)
Засгийн газрын оруулсан капитал / засгийн газрын сан, орон нутгийн сан/	54,610.9	-	(54,610.9)
Хуримтлагдсан үр дүн	(1,461,314.3)	2,302,273.3	3,763,587.6
Өмнөх оны үр дүн	(356,558.9)	783,394.5	1,139,953.4
Тайлант оны үр дүн	(1,104,755.4)	1,518,878.8	2,623,634.2
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	783,394.50	2,302,273.30	1,518,878.80

Мөнгөн хөрөнгө: Төсөл нь тайлант оны эцэст ам.долларын дансны үлдэгдэл 999,605.0 мянган төгрөг, төгрөгийн дансдын нийт үлдэгдэл 36,050.0 мянган төгрөг тайлагнасан.

Урьдчилж гарсан зардал: Шатахууны зардлын 717.9 мянган төгрөгийн үлдэгдэл тайлагнасан.

Үндсэн хөрөнгө болон биет бус хөрөнгө: АХБ-ны санхүүжилтээр төслийн нэгжийн үйл ажиллагаанд зориулан худалдан авсан нийт 2,684.2 мянган төгрөгийн компьютерийн дагалдах хэрэгсэл, тавилга эд хогшлыг үндсэн хөрөнгөөр бүртгэсэн. Тайлант хугацаанд үндсэн хөрөнгө болон биет бус хөрөнгөнд нийт 23,585.7 мянган төгрөгийн элэгдэл байгуулж зардлаар бүртгэсэн.

Дуусаагүй барилга: Төсөл мэргэжлийн хяналтын болон мал эмнэлгийн лабораториудын барилгын зураг төсөл боловсруулах ажил гүйцэтгэх 289,230.0 ам.долларын зөвлөх үйлчилгээний гэрээ, хорио цээрийн байгууламжийн загвар, зураг төсөв боловсруулах ажил гүйцэтгэх 183,490.0 ам.долларын зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулсан. Төсөл эдгээр ажлын гэрээний явцын болон эцсийн төлбөр нийт 1,139,697.1 мянган төгрөгийг Дуусаагүй барилга дансанд хуримтлуулан бүртгэсэн.

Урт хугацаат өр төлбөр болон өмнөх оны үр дүн:

Өмнөх тайлант хугацааны аудитаар өгсөн зөвлөмжийн дагуу төслийн санхүүгийн байдлын тайланд урт хугацаат өр төлбөрөөр хуримтлуулан бүртгэсэн АХБ-ны зээлийн нийт дүн 2,190,097.9 мянган төгрөгийг өмнөх оны үр дүн рүү хааж залруулсан.

Засгийн газрын оруулсан капитал болон өмнөх оны үр дүн:

Тайлант хугацааны аудитаар өмнөх тайлант хугацааны зөвлөх үйлчилгээний төлбөр, үндсэн хөрөнгийн худалдан авалт болон төслийн үйл ажиллагааны зардалд тооцсон нэмэгдсэн өртгийн албан татварын чөлөөлөлт 54,610.9 мянган төгрөгийг Засгийн газрын хөрөнгө оруулсан капитал дансанд бүртгэсэн байсныг өмнөх оны үр дүн рүү хааж залруулсан.

2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

“Ургамал, малын эрүүл ахуй, хүнсний аюулгүй байдлыг хангах арга хэрэгслийг сайжруулах төсөл”-ийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхтэй холбоотой зардлыг санхүүжүүлэхэд зориулан 2019 онд 2,469,478.0 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 1,189,478.0 мянган төгрөгийг урсгалд зардалд, 1,280,000.0 мянган төгрөгийн хөрөнгийн зардалд тус тус зарцуулахаар батлагджээ.

Төсвийн орлогын гүйцэтгэл 2,257,282.6 мянган төгрөг буюу 91.4 хувьтай байна. Төсвийн урсгал зардлын гүйцэтгэл 769,483.3 мянган төгрөг буюу 64.7 хувь, хөрөнгийн зардлын гүйцэтгэл 1,139,697 мянган төгрөг буюу 89.0 хувьтай байна.

Хүснэгт 2. Төсвийн орлого

/ мянган төгрөг/

Санхүүжилтийн төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	2,469,478.0	2,257,282.6	212,195.4	91.4
Нийт дүн	2,469,478.0	2,257,282.6	212,195.4	91.4

Хүснэгт 3. Төсвийн зардал

/ мянган төгрөг/

Зарцуулалтын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Урсгал зардал	1,189,478.0	769,483.3	419,994.7	64.7
Хөрөнгийн зардал	1,280,000.0	1,139,697.1	140,302.9	89.0
Нийт дүн	2,469,478.0	1,909,180.4	560,297.6	77.3

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд 2 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 1 эрсдэл тодорхойлж нийт 3 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 224,233.7 мянган төгрөгийн алдаа зөрчлийг илрүүлсэнээс 224,233.7 мянган төгрөгийн 2 алдааг залруулж, алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

Аудитын явцад санхүүгийн тайланд дараах 2 залруулгыг хийв. Үүнд:

Санхүүгийн үр дүнгийн тайланд АХБ-ны зээлийн хүүгийн төлбөр 53,561.5 мянган төгрөгийг гадаадын эх үүсвэрээс санхүүжих орлого болон банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамжийн дансанд тус тус бүртгэсэн байсан.

Шийдвэрлэсэн нь: Сангийн яамнаас төсөл хэрэгжүүлэгч нэгжийн санхүүгийн тайланд АХБ-ны зээлийн төлбөрийг бүртгэхгүй байх чиглэл өгсөн учраас гадаадын эх үүсвэрээс санхүүжих орлогын данс, банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамжийн дансыг 53,561.5 мянган төгрөгөөр тус тус бууруулж залруулсан.

Зөвлөх үйлчилгээний төлбөр, үндсэн хөрөнгийн худалдан авалт болон төслийн үйл ажиллагааны зардалд өмнөх тайлант хугацаанд тооцсон нэмэгдсэн өртгийн албан татварын чөлөөлөлт 54,610.9 мянган төгрөг, энэ тайлант хугацаанд тооцсон нэмэгдсэн өртгийн албан татварын чөлөөлөлт 116,061.3 мянган төгрөгийг Засгийн газрын оруулсан капитал дансанд хуримтлуулан бүртгэсэн байсан.

Шийдвэрлэсэн нь: Сангийн яамнаас төсөл хэрэгжүүлэгч нэгжийн санхүүгийн тайланд МУЗГ-ийн санхүүжилтээр тооцох нэмэгдсэн өртгийн албан татварын чөлөөлөлтийг тайлант хугацааны санхүүжилтээр бүртгэх чиглэл өгсөн учраас өмнөх тайлант хугацааны нэмэгдсэн өртгийн албан татварын чөлөөлөлт 54,610.9 мянган төгрөгийг өмнөх оны үр дүн рүү хааж, энэ тайлант хугацааны нэмэгдсэн өртгийн албан татварын чөлөөлөлт 116,061.3 мянган төгрөгийг санхүүгийн үр дүнгийн тайлан руу тус тус хааж залруулсан.

2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Дараагийн аудитаар дор дурдсан асуудлуудыг анхаарч үзэх шаардлагатай. Үүнд:

- Төсвийн тухай хуульд олон улсын төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх төслийн нэгж нь төсвийн байгууллага байхаар зааснаар нягтлан бодох бүртгэлээ УСНББОУС-ын дагуу бүрэн аккруэл сууриар бүртгэхтэй холбоотойгоор олон улсын төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх нэгжийн үйл ажиллагаанд тохирсон нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын нэгдсэн заавар, аргачлалыг Сангийн яамнаас тусгайлан гаргах хэрэгтэй байна. Уг заавар, аргачлалд төслийн нэгж нь АХБ-ны зарцуулалтын үндсэн процедур болох шууд төлбөр, урьдчилгаа төлбөр, нөхөн дүүргэлтийг аккруэль сууриар хэрхэн хүлээн зөвшөөрч бүртгэж тайлагнах, хүлээн

авсан болон зарцуулсан санхүүжилтэнд гадаад валютын ханшийг хэрхэн ашиглах, төслийн санхүүжилтээр бий болсон биет болон биет бус хөрөнгийг элэгдүүлэх хугацаа болон арга, төслийн санхүүжилтээр хийгдэж байгаа барилга, байгууламж, тоног төхөөрөмжийг хэрхэн хуримтлуулан бүртгэх, хөрөнгийг төсөл дуусахад төрийн өмчид шилжүүлэх, зээл тусламжийг төслийн нягтлан бодох бүртгэлд өр төлбөрөөр тусгах эсэх, зээлийн хүүгийн өр төлбөрийг хэрхэн бүртгэх;

- Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд шаардсан мэдээллийг бүрэн оруулсан эсэхийг хянах;
- Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн төлөвлөгөө болон төсвийн гүйцэтгэлийн үзүүлэлтүүдийг эдийн засгийн ангиллаар нь задалж тайлагнаж байгаа эсэхийг хянах;
- АХБ-наас 2019 оны 03 дугаар сард хийсэн үнэлгээгээр төслийн худалдан авалтын үйл ажиллагааны үйл явц удаашралтай, зарцуулалтын доогуур байгаа шалтгаан нь ТХН-ийн ажилтнуудын АХБ-ны санхүүжилттэй төсөл удирдах туршлага хангалтгүй, гэрээний удирдлага муу байгаатай холбоотой гэж дүгнэсэн. Төслийн дуусах хугацаа 2021 оны 6 дугаар сарын 30 бөгөөд 2020 онд багтаан барилгын ажил, зөвлөх үйлчилгээ болон бараа худалдан авалтын томоохон гэрээнүүд хийгдэхээр төлөвлөсөн.

2.12. Шилэн дансны мэдээлэл

“Ургамал, малын эрүүл ахуй, хүнсний аюулгүй байдлыг хангах арга хэрэгслийг сайжруулах төсөл” нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 75 мэдээллийг хугацаанд нь, 66 мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан байна.

2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 2,190,097.9 мянган төгрөгийн зөрчилд хүргүүлсэн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлсэн.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид “Ургамал, малын эрүүл ахуй, хүнсний аюулгүй байдлыг хангах арга хэрэгслийг сайжруулах төсөл”-ийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

“Ургамал, малын эрүүл ахуй, хүнсний аюулгүй байдлыг хангах арга хэрэгслийг сайжруулах төсөл”-ийн 2019 оны санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Санхүүгийн программ хангамжийн талаар

3.1.1 Илрүүлэлт:

Төсөл нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд “Инфосистемс” ХХК-ийн “Пакс” санхүүгийн программ хангамж ашигладаг.

Тус программ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцээгүй, харин АХБ-ны Зарцуулалтын журмын шаардлагын дагуу мөнгөн сууриар нягтлан бодох бүртгэл хөтлөхөөр тохируулга хийгдсэн байна.

Энэ нь иж бүрэн байх, үнэн зөв байх, тодруулга ба толилуулга, үнэлгээ ба хуваарилалт гэсэн батламж мэдэгдэлтэй нийцээгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14-р зүйлийн заалттай нийцэхгүй байна.

3.1.2 Эрсдэл:

Төслийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал буруу, алдаатай бэлтгэгдэх.

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Төслийн санхүүгийн программыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-ын шаардлагад нийцүүлсэн байдлаар шинэчлэх, холбогдох өөрчлөлт оруулах.

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Төслүүдийн хувьд төсөвт байгууллагаас ерөнхийдөө ялгаатай байдаг тул цэвэр төсөвт байгууллагын тайлан бэлтгэдэг программ хангамж ашиглах боломжгүй байдаг Гэтэл Монгол улсад одоогоор бидний ашиглаж байгаагаас өөр ам доллар төгрөгөөр зэрэгцүүлэн гүйлгээг бүртгэдэг, мөн Донор байгууллагын тайлагналтын шаардлагад нийцэх программ хангамж байхгүй байна. Сангийн яамнаас төслийн санхүүгийн

бүртгэлийн бодлого дээр нэгдсэн байр суурьтай бодлогын зөвлөмж байхгүй байна. Иймд хэрэв таарах программ хангамж байвал зөвлөмжийг хэрэгжүүлнэ.

3.2 Шилэн дансны мэдээллийн талаар

3.2.1 Илрүүлэлт:

Төсөл нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 75 мэдээллийг хугацаанд нь, 66 мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан байна.

3.2.2 Эрсдэл:

Шилэн дансны тухай хууль зөрчих;

3.2.3 Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасны дагуу мэдээллийг тогтсон хугацаанд нь бүрэн гүйцэт оруулах.

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Шилэн дансанд систем алдаа зааж ашиглах боломжгүй байдалтай байснаас хамаарч холбогдох 66 мэдээллийг хугацаа хоцорч оруулсан.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 07 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН (I)	636,289,696.81	1,036,372,923.66
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	636,289,696.81	1,035,655,022.14
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	636,289,696.81	1,035,655,022.14
31210	Төгрөг	22,643,448.76	36,050,002.43
31211	Төрийн сангийн харилцах	22,643,448.76	36,050,002.43
31220	Гадаад валют	613,646,248.05	999,605,019.71
31223	Арилжааны банк дахь харилцах	613,646,248.05	999,605,019.71
34	УРЬДЧИЛГАА	-	717,901.52
34600	Урьдчилж гарсан зардал	-	717,901.52
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН (II)	147,104,796.06	1,265,900,404.64
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	143,194,796.06	1,265,900,404.64
39200	Биет хөрөнгө	143,194,796.06	1,262,450,404.64
39202	Авто тээврийн хэрэгсэл	131,000,000.00	131,000,000.00
39203	Хуримтлагдсан элэгдэл - Авто тээврийн хэрэгсэл	(17,466,666.67)	(30,566,666.67)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	29,002,025.61	30,607,471.15
39206	Хуримтлагдсан элэгдэл - Тоног төхөөрөмж	(10,675,785.55)	(19,325,629.17)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	12,957,454.54	14,036,272.72
39208	Хуримтлагдсан элэгдэл - Тавилга	(1,622,231.87)	(2,998,137.93)
39216	Дуусаагүй барилга, байгууламж	-	1,139,697,094.54
39300	Биет бус хөрөнгө	3,910,000.00	3,450,000.00
39301	Санхүүгийн програм	4,600,000.00	4,600,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл - Санхүүгийн програм	(690,000.00)	(1,150,000.00)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН (III=I+II)	783,394,492.87	2,302,273,328.30
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР (IV)	2,190,097,899.09	-
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	-
422240	АХБ-ны хөнгөлөлттэй зээл	2,190,097,899.09	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН (V)	(1,406,703,406.22)	2,302,273,328.30
51	Засгийн газрын хувь оролцоо	54,610,901.88	2,302,273,328.30
51100	Засгийн газрын хувь оруулсан капитал	54,610,901.88	-
51	Хуримтлагдсан үр дүн	(1,461,314,308.10)	2,302,273,328.30
51200	Хуримтлагдсан үр дүн	(356,558,887.03)	783,394,492.86
51220	Тайлант үеийн үр дүн	(1,104,755,421.07)	1,518,878,835.44
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН (VI=IV+V)	783,394,492.87	2,302,273,328.30

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

		/ төгрөгөөр /	
Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	32,539,385.58	2,392,063,286.25
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	32,539,385.58	2,392,063,286.25
120002	Туслах үйл ажиллагааны орлого	4,813,261.48	10,238,753.43
120009	Бусад орлого	-	8,480,564.80
1200044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	-	2,257,282,638.65
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	27,663,267.10	-
134002	Нийгмийн даатгалын сангаас	62,857.00	-
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	-	116,061,329.37
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	-	906,512,892.22
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	906,512,892.22
210	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,121,737,032.08	906,512,892.22
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	512,030,065.44	434,224,877.10
210101	Үндсэн цалин	459,101,080.88	434,224,877.10
2102	Нийгмийн даатгалын шимтгэл	52,928,984.56	51,481,789.62
210201	Тэтгэврийн даатгал	36,685,407.95	36,467,114.55
210202	Тэтгэмжийн даатгал	3,669,791.51	4,290,248.76
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,587,239.39	3,432,199.02
210204	Ажилгүйдлийн даатгал	711,666.95	662,929.75
210205	Эрүүл мэндийн даатгал	7,274,878.76	6,629,297.54
2104	Байрны түрээс	46,026,496.82	47,972,273.82
	Хангамж, бараа материалын зардал	12,068,505.64	12,574,860.27
210401	Бичиг хэрэг	4,434,945.80	3,978,067.33
210402	Тээвэр, шатахуун	3,625,000.00	650,000.00
210403	Шуудан, холбоо	2,358,295.30	2,305,207.19
210406	БҮТЭЗ	1,650,264.54	5,641,585.75
	Томилолт зочны зардал	73,776,225.10	5,630,198.48
210701	Гадаад албан томилолт	68,197,975.10	-
210702	Дотоод албан томилолт	5,578,250.00	5,630,198.48
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	452,713,932.90	210,155,245.21
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр	412,846,424.34	194,154,757.72
210802	Аудит баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	3,360,000.00	7,174,896.30
210803	Даатгалын үйлчилгээ	1,761,280.00	2,848,036.00
210804	Тээврийн хэрэгсэлийн татвар	175,548.00	170,548.00
210806	Мэдээлэл технологийн үйлчилгээ	1,000,000.00	5,399,634.72
210808	Банк санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	33,570,680.56	407,372.47
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	25,121,806.18	144,473,647.72
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,969,000.00	120,887,898.04
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдол	22,152,806.18	23,585,749.68
	ҮАжиллагааны зардал ЗГ санхүүжилтээр	13,984,099.99	-
	ҮАжиллагааны зардал ЗГ санхүүжилтээр	13,984,099.99	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II)	-	1,485,550,394.03
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН (IV)	-	33,328,441.41
14	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГО	-	33,328,441.41
145	Бусад орлого (олз)	-	-
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	-	33,328,441.41
5	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V)	-	-
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДАЛ	1,573,674.58	-
225004	Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	1,573,674.58	-
6	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI=III+IV-V)	(1,104,755,421.07)	1,518,878,835.44

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/ төгрөгөөр /			
Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	1,026,205,942.40	2,911,506,994.28
	Татаас санхүүжилтийн орлого	993,666,556.81	-
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	32,539,385.59	2,911,506,994.28
1200	Нийтлэг татварын бус орлого	-	17,934,658.82
120004	Туслах үйл ажиллагааны орлого	4,813,261.48	10,238,753.43
120009	Бусад орлого	-	7,695,905.39
1200047	Шилжиж ирсэн мөнгөн хөрөнгө	-	636,289,696.81
145001	Гадаад валютын ханшийн олз	27,663,267.10	-
	Нийгмийн даатгалын сангаас	62,857.00	-
1200044	Гадаад эх үүсвэрээс санхүүжих	-	2,257,282,638.65
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)	-	766,799,055.29
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	766,799,055.29
210	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,066,571,750.04	766,799,055.29
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	512,030,065.44	-
210101	Үндсэн цалин	459,101,080.88	-
2102	Нийгмийн даатгалын шимтгэл	52,928,984.56	-
210201	Тэтгэврийн даатгал	36,685,407.95	-
210202	Тэтгэмжийн даатгал	3,669,791.51	-
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,587,239.39	-
210204	Ажилгүйдлийн даатгал	711,666.95	-
210205	Эрүүл мэндийн даатгал	7,274,878.76	-
2104	Байрны түрээс	46,026,496.82	40,090,454.55
210304	Байрны түрээс	46,026,496.82	40,090,454.55
2104	Хангамж, бараа материалын зардал	12,068,505.64	12,574,860.27
210401	Бичиг хэрэг	4,434,945.80	3,978,067.33
210402	Тээвэр, шатахуун	3,625,000.00	650,000.00
210403	Шуудан, холбоо	2,358,295.30	2,305,207.19
210406	Бага үнэтэй түргэн элэгдэх зүйл	1,650,264.54	5,641,585.75
2107	Томилолт зочны зардал	73,776,225.10	6,348,100.00
210701	Гадаад албан томилолт	68,197,975.10	-
210702	Дотоод албан томилолт	5,578,250.00	6,348,100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	419,701,457.04	703,743,731.20
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр	412,846,424.34	703,743,731.20
210802	Аудит баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	3,360,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	1,761,280.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	175,548.00	-
210806	Мэдээлэл технологийн үйлчилгээ	1,000,000.00	-
210808	Банк санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	558,204.70	-
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,969,000.00	4,041,909.27
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III=I-II)	(40,365,807.64)	2,144,707,938.99
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)	-	-
145	Бусад орлого (олз)	-	-
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	-	-
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН	-	1,142,381,358.26

	ЗАРДЛЫН ДҮН (V)		
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	1,142,381,358.26
22	Барилга	-	1,139,697,094.54
220001	Барилга, байгууламж	-	1,139,697,094.54
222001	Тоног төхөөрөмж	-	-
223	БУСАД ХӨРӨНГӨ	-	2,684,263.72
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	3,575,331.63	2,684,263.72
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДАЛ	-	-
225004	Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	-	-
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI=IV-V)	(3,575,331.63)	(1,142,381,358.26)
9	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	-	-
10	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	-	-
225004	Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	1,573,674.58	-
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VII)	(1,573,674.58)	33,328,441.41
	Бусад эх үүсвэр	-	-
	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	-	33,328,441.41
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII=III+VI+VII)	(45,514,813.85)	1,035,655,022.14
14	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	681,804,510.66	-
15	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	636,289,696.81	1,035,655,022.14

4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/ төгрөгөөр /

Үзүүлэлт	Засгийн газрын хөрөнгө оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны дүн
2017 оны 12 сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	-	-	-
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					
Дахин илэрхийлсэн үлдэгдэл					
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт					
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт					
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөгдөөгүй олз, гарз					
Тайлант үеийн үр дүн	54,610,901.88		(1,461,314,308.10)		(1,406,703,406.22)
2018 оны 12 сарын 31-нээрх үлдэгдэл	54,610,901.88		(1,461,314,308.10)		(1,406,703,406.22)
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			2,244,708,800.96		
Дахин илэрхийлсэн үлдэгдэл			783,394,492.86		783,394,492.86
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт					
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт					
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөгдөөгүй олз, гарз					
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү					
Тайлант үеийн үр дүн			1,518,878,835.44		1,518,878,835.44
2019 оны 12 сарын 31-нээрх үлдэгдэл		-	2,302,273,328.30	-	2,302,273,328.30

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/ төгрөгөөр /					
Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Гүйцэтгэлийн зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)	2,469,478,000.00	1,909,180,413.55	560,297,586.45	77.31%
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,189,478,000.00	769,483,319.01	419,994,680.99	64.69%
210	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,189,478,000.00	769,483,319.01	419,994,680.99	64.69%
2103	Байр ашиглалттай холбоотой зардал	48,648,000.00	40,090,454.55	8,557,545.45	82.41%
210304	Байрны түрээс	48,648,000.00	40,090,454.55	8,557,545.45	82.41%
2104	Хангамж, бараа материалын зардал	51,000,000.00	12,574,860.27	38,425,139.73	24.66%
210401	Бичиг хэрэг	12,000,000.00	3,978,067.33	8,021,932.67	33.15%
210402	Тээвэр, шатахуун	15,000,000.00	650,000.00	14,350,000.00	4.33%
210403	Шуудан, холбоо	12,000,000.00	2,305,207.19	9,694,792.81	19.21%
210406	Бага үнэтэй түргэн элэгдэх зүйл	12,000,000.00	5,641,585.75	6,358,414.25	47.01%
2107	Томилолт зочны зардал	139,060,000.00	6,348,100.00	132,711,900.00	4.57%
210701	Гадаад албан томилолт	96,000,000.00	0.00	96,000,000.00	0.00%
210702	Дотоод албан томилолт	43,060,000.00	6,348,100.00	36,711,900.00	14.74%
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	920,770,000.00	703,743,731.20	217,026,268.80	76.43%
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр	920,770,000.00	703,743,731.20	217,026,268.80	76.43%
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	30,000,000.00	6,726,172.99	23,273,827.01	22.42%
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	30,000,000.00	6,726,172.99	23,273,827.01	22.42%
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,280,000,000.00	1,139,697,094.54	140,302,905.46	89.04%
222001	Барилга байгууламж	1,280,000,000.00	1,139,697,094.54	140,302,905.46	89.04%
III	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	2,469,478,000.00	2,267,521,392.08	201,956,607.92	81.78%
35	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	2,469,478,000.00	2,267,521,392.08	201,956,607.92	81.78%
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	10,238,753.43	-	-
350004	Гадаад эх үүсвэрээс санхүүжих	2,469,478,000.00	2,257,282,638.65	212,195,361.35	91.41%
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		1,002,326,580.73		
6	АЖИЛЛАГСАДЫН ТОО				
	Гэрээт ажилтан		10		

5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо: 2020.04.27	Аудитын нэр: “Ургамал, малын эрүүл ахуй, хүнсний аюулгүй байдлыг хангах арга хэрэгслийг сайжруулах төсөл”-ийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит	Аудитын код: САГ-2020/732/СТА-ТХН
Шалгагдсан байгууллагын нэр:	“Ургамал, малын эрүүл ахуй, хүнсний аюулгүй байдлыг хангах арга хэрэгслийг сайжруулах төсөл”	Мянган төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Төсөл нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд “Инфосистемс” ХХК-ийн “Пакс” санхүүгийн программ хангамж ашигладаг. Тус программ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцээгүй, харин АХБ-ны Зарцуулалтын журмын шаардлагын дагуу мөнгөн сууриар нягтлан бодох бүртгэл хөтлөхөөр тохируулга хийгдсэн байна. Энэ нь иж бүрэн байх, үнэн зөв байх, тодруулга ба толилуулга, үнэлгээ ба хуваарилалт гэсэн батламж мэдэгдэлтэй нийцээгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14-р зүйлийн заалттай нийцэхгүй байна.	-	Зөвлөмж өгөх	Төслийн зохицуулагч	Э. Цогоо
2	Төсөл нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 75 мэдээллийг хугацаанд нь, 66 мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан байна.	-	Зөвлөмж өгөх	Төслийн зохицуулагч	Э. Цогоо
	Зөвлөмжийн дүн	-			